

**“Хай Би Ойл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2017.04.26-ны өдрийн ээлжит хурлын
тэмдэглэл**

2017.04.26

Улаанбаатар хот

“Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 04 сарын 26-ны өдрийн 14 цаг 05 минутанд Баянгол зочид буудлын хурлын өрөөнд эхлэв.

Хуралд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Гүйцэтгэх захирал Ө.Хүдрээ, Санхүү эрхэлсэн захирал Б.Пүрэвбаатар, хурал зохион байгуулах комиссын гишүүн Ж.Энхцэцэг, Тооллогын комиссын даргаар Б.Мянганбаяр, гишүүдээр Ж.Энхцэцэг, Б.Энхцэцэг, Б.Энхням нар мөн нийт 9 хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар, 4 хувьцаа эзэмшигчид өөрийн биеэр оролцов.

Тооллогын комиссын дарга Б.Мянганбаяр: “Хай Би Ойл” ХК-ийн 2017 оны 04 сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг та бүхэнд танилцуулья. Нийт 52,118,954 хувьцаанаас нийтдээ 79,60% буюу 41,487,915 ширхэг хувьцаа эзэмшиж буй 13 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэйгээр хурлын ирц бүрдэж байгааг мэдэгдье.

Хурлын дарга Ө.Хүдрээ: Хувьцаа эзэмшигчдийн энэ өдрийн мэнд хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ээлжит хурлын дэгийг та бүхэнд танилцуулья.

- ✓ Хурлын ирцийг бүртгэх
- ✓ Хурлын ирцийг мэдээлэх
- ✓ Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах
- ✓ Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал авах
- ✓ Хурлын завсарлага
- ✓ Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах
- ✓ Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах
- ✓ Хурлыг хаах

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2017 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2017 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Хурлын дарга Ө.Хүдрээ: Үйлдвэрийнүйл ажиллагааны талаар таинилцуулья. Үйлдвэрийн ажилчид 2017 оны 3 сарын 1–с цуглараад урсгал засвараа 4 сарын 1 хүртэл амжуулж хийдэг. Өвөл 12 сарын 30 хүртэл түүхий эдээ цуглуулж, 11-12 сард нэлээн түлхүү ажилласан. Өнөөдрийн байдлаар эхнийхээ нийлүүлэлтийг хийгээд эхэлж байна. Боловсруулсан мазут одоогоор 70 гаруй тонн байгаа, түүхий эд өвлөөс цуглуулсан нь 3 сарын 6 –ний байдлаар 50 гаруй тоннтой байсан, өнөөдрийн байдлаар 170 орчим тонн түүхий эдийн нөөцтэйгээр энэ жилийн үйл ажиллагааг эхэлж байна. Өнгөрсөн жил тодорхой хэмжээний зардал чиглэлээр бууруулах технологийн өөрчлөлтүүд хийсэн байгаа. Та бүхэн зурган дээр харж байгаа байх, халаалтын системээ сайжруулж бэлэн бүтээгдхүүнээ гаргах хугацаагаа багасгах, мөн цахилгааны хэмнэлт үүсгэх ийм зорилготой. Мөн түүнчлэн хуучирч хатуурсан уян шугам хоолойг шинэчлэж, үйлдвэрийн хөргөлтийн насос болон бэлэн бүтээгдэхүүний гадна савнаас мазут ачих насос эвдэрчсэн учир дахин ороолгож засуулсан. Насосыг солиход шугам хоолойд бага зэргийн засвар орсон. Галын болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүднээс аюулгүй ажиллагааны анхааруулах болон заах зурагт хуудас, самбар, тэмдэг, тэмдэглэгээ, наалт, галын хорыг шинэчлэж, галын булан, галын сарайг өөрсдөө гагнаж хийсэн. Ажилчдын аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлж улирлын нормын дулаан хувцас, гутал, хэрэглэлийг авсан. Мөн үйлдвэрийн хашаан дотор 20 настай 5 ширхэг гацуур модыг худалдан авч тарьж ургуулж байна. Ажилчдыг тээвэрлэх унаа машин болон тосны цистернд ээлжит урсгал засвар, улсын үзлэг, оношилгоонд хамруулж, АТБӨЯТХ-ийн татвар, хот дотор тос тээвэрлэх түр зөвшөөрлийг 2016 он дуустал авсан байна.

Бусдаар бол үйлдвэрлэлд саатах хэмжээний гэмтэл гараагүй. Төхижилтын ажилд тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулсан. Өмнөх оны хурлаар баталсан төсөвдөө багтааж, тэр төсвөөс дараа ондоо шилжүүлээд, үйл ажиллагааны зардалыг бага байлгах зорилгоор тодорхой хэмжээний ажлууд хийж байна. 2016 оны борлуулалт 2015 оны борлуулалтаас бага гарсан байна. Энэ бас тодорхой шалтгаан байсан. 1рт 2016 оны замын ажлууд концессийн гэрээгээр хийгдсэн. Үүнийг дагаад ажил хийж байгаа компаниуд дандаа өөрийн хөрөнгөөр гүйцэтгэл багатай ажилласан учраас манай компанитай байгуулсан гэрээний дагуу татаж авах ёстой мазутаа бага хэмжээгээр авсан учраас борлуулалт буурсан байгаа. Энэ жилийн тухайд худалдан авагч компаниуд бүгдээрээ гэрээгээ шинэчлээд дуусаж байна, энэ жилийн үнээ дахиж 900 болгож өсгөсөн байгаа. Урьдчилсан байдлаар өнгөрсөн жилийн түүхий эд татаж авах, бэлэн бүтээгдхүүнээ нийлүүлээд одоогийн байдлаар 700 орчим тонн захиалга аваад байна. Энэ жилийн борлуулалт өмнөх жилийнхээс өсөх болов уу гэсэн төсөөлөлтэй байна. Өнгөрсөн жилийн үйл ажиллагаанд аудитын хороо аудит явуулж тайлан гаргаж өгсөн байгаа. Хурлын материалд байна, тодруулж асуух зүйл байвал асууж болно.

2015-2017 оны борлуулалтаа харьцуулж хурлын материалд оруулж өгсөн байгаа. Үйлдвэртэй холбоотой үйл ажиллагааны талаар товчхон та бүхэнд танилцуулга хийлээ. Хойд Солонгостой холбоотой мэдээллийг компанийн санхүү эрхэлсэн захирал Б.Пүрэвбаатар хүргэнээ.

Санхүү эрхэлсэн захирал Б.Пүрэвбаатар: 2016 онд манай компани Ардчилсан Солонгосын төсөл дээр бол улс төрийн эрсдэл үүсэх магадлалтай гэж үзээд бүх зардлаа зогсоосон байсан. Тайлант хугацаанд хөрөнгө оруулалт болон ажил гүйлгээний зардал гаргаагүй. Өмнөх жилийн хувьцаа эзэмшигчидийн хурдаар ярьж байсаны дагуу тухайн үед датарум геологийн мэдээлэл шилжүүлж аян гэж ярьж байсан, авсан тохиодолд бидний мэдэлд ирээд эндээ зардал гарах магадлалтай, хийгдэхгүй бол ямар нэгэн зардал гарахгүй байсан ба ийм байр суурьтай 2016 онд ажилласан. 2017 оны 1 сарын 10-ны өдөр АНУ-н сангийн яамны харьяа агентлаг байдаг. /OFAC-Office of foreign assets control буюу гадны хөрөнгүүдэд хориг арга хэмжээтэй жагсаалтыг шинэчилдэг агентлаг юм/. Энэ агентлагаас 2017 оны 1 сарын эхээр мэдээлэл гарсан, Хойд солонгосын эсрэг DPRK 3 гэсэн хориг арга хэмжээний жагсаалт АНУ-н ЗГ-с баталсан. Энэ дотор Хойд Солонгосын газрын тосны 2 компанийн нэрийг шинээр оруулж ирсэн байгаа. Тэр компанийн нэг нь Korwan Oil Exploration Corporation буюу манай компанитай хамтарч ажиллаж байсан компани байгаа. OFAC нь хэдийгээр АНУ-н Сангийн яамны харьяа боловч ерөнхийдөө ихэнх олон улсын клирингийн банкны төлбөр тооцооны гүйлгээн дээр OFAC жагсаалт хүчтэй үйлчилдэг. Манай компанийн ТУЗ уг тогтоол гарсаны дараагаар нь яаралтай 2 өдрийн дотор хуралдсан байгаа. Энэ хурлаар улс төрийн нөхцөлөөс шалтгаалан гэрээний нөхцөл дээр давагдашгүй хүчин зүйлд орж байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. OFAC хар жагсаалтад орсон байгууллагад гүйлгээ харилцаанд орж болохгүй, хэрэв тийм юманд орохын бол нөгөө харилцсан компани нь өөрөө хар жагсаалтанд ордог эрсдэл байдаг. Ингээд манай компанийн зүгээс яаралтай мэдээллүүдийг хэвлэл мэдээллээр гаргаж, Хороо, Хөрөнгийн биржэд мэдээллээ хүргүүлсэн байгаа. Хувьцаа эзэмшигчид энэ тухай мэдээлэл авсан байх. OFAC жагсаалтад орсон дагуу ТУЗ- с тогтоол гараад Хойд Солонгосын хамтарсан компанийн 20 хувийг эзэмшдэг байсан. Энэ 20 хувийнхаа эзэмшлээс шууд татгалзахаас өөр зам байхгүй байсан. Ийм шийдэлд хүрсэн байгаа. Нөхцөл байдал 1 сараас хойш бүр илүү дордсон, Солонгосын Хойгийн асуудал аюултай нөхцөлл байдалд орчоод байна. Анх хөрөнгө оруулалт хийж байх үед хойд солонгосын төрийн өмчтэй компаниудыг оруулдаггүй байсан. Зөвхөн цөмийн эрчим хүчний салбар, батлан хамгаалахын салбар компаниудын жагсаалтыг оруулж байснаас биш өмнө нь ийм тохиолдол хэзээ ч байгаагүй. АНУ мэдэж байгаа бүх төрийн өмчтэй компаниудыг жагсаалтад оруулсан. OFAC жагсаалт банкны хувьд ир эрсдэлтэй байдаг. Монгол улсын хувьд OFAC жагсаалтыг дагаж мөрдөх мөрдөхгүй гэсэн хуулийн заалт байхгүй. Та бүхэнд энэ жагсаалтыг өгье.

Одоо Ардчилсан Солонгосд хийсэн хөрөнгө оруулалтаас бид татгалзах боллоо, ямар үр дагавар граж ирэх вэ, компани ямар бодитой алдагдалд орох вэ гэсэн зүйлс, хасалтууд яригдаж байгаа.

Манай дээр БДО аудит хараат бус аудитын тайлан гаргасан, сүүлийн 3 жил манайхтай хамтарч ажиллаж байгаа. Баланс дээрээ бид алдагдлаа бүртгээгүй байсан, 2016 тайланд энэ хамаарахгүй.

1 сарын үед гарсан жагсаалт тул 2017 оны 1 улирлын тайланд тусгах ёстой. Аудитын тайланг тараасан байгаа, компанийн сайтад байршуулна. Хязгаарлалттай дүгнэлтийг уншаад танилцуулья. Компанийн удирдлага тэмдэглэл 15 Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт-

д дурдасан хараат компани болох КОЕСII компани дах хөрөнгө оруулалт, тэмдэглэл 16 өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт-д дурдсан Сингапур улсын хуудийн этгээд “Блэктип Энержи Лимитед/ комданийн нэг бүр нь нь 0.36 Сингапур долларын үнэтэй 3,633,450 ширхэг энгийн хувьцаа /нийт энгийн хувьцааны 13%/-нд оруулсан хөрөнгө оруулалт-д 2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр аливаа үнэ цэнийн бууралтын нөөц байгуулаагүй байна. Бид аудитын явцад эдгээр гадаад дах хөрөнгө оруулалтуудын бодит үнэ цэнийн тооцооллыг баталгаажуулахтай холбоотой мэргэжлийн экспертийнх ажлыг ашиглах эсвэл өөр аудитын горим гүйцэтгэх боломжгүй байсан тул аливаа үнийн бууралт байхгүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоо цуглуулах замаар аудитын эерэг санал дүгнэлт гаргах боломжгүй байсан. Санхүүгийн тайлангийн тэмдэглэл 32-д дурдсанчлан компанийн ТУЗ-ийн 2017 оны 1 сарын 17-ны өдрийн шийдвэрийн дагуу компани эдгээр хөрөнгө оруулалтаас хамгийн багадаа 3,260,278 мянган төгрөгийн алдагдлыг 2017 оны санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх болно.

Бидний алдагдлаар тооцоогүй зүйлийг хараат бус аудитын компани учирч болох эрсдэл гэж үзээд эрсдэлийн сан үүсгээд оруулсан байгаа. Онцлох асуудал дээр бол Шарын гол ХК-иас авах нийт 1,975,767 мянган төгрөгийн авлага эргэн төлөгдөх эсэх нь “Хай Би Ойл” ХК болон “Шарын гол/ ХК-ийн компанийн аль алиных нь томоохон хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гаргалтаас хамаарахаар байгааг энэхүү санхүүгийн тайланг хэрэглэгчдийн анхааралд хүргэж байна. Бид энэхүү харилцан хамаарал бүхий талаас авах авлагатай холбоотойгоор дээр гаргасан дүгнэлтийн хэлбэрийг өөрчлөөгүй болно.

ОFAC жагсаалттай холбоотой 3,260,278 мянган төгрөгийн алдагдал нь компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх вэ, хүнд байдалд орох уу гэж асуудаг. Түрүүн Хүдрээ захирал ярьсан монгол дах үйл ажиллагаа байсан, өмнө байсаар ирсэн, Хойд Солонгосын хөрөнгө оруулалтын ажил 2013 онд хийгдэж байсан, тухайн үед хийгдэхдээ санхүүжилтээр босгосон хөрөнгө оруулалтаар хийсэн, ямар нэгэн өр зээлэнд ороогүй, гол хөрөнгө оруулагч нарын шийдвэр байсан. Энийг бас онцолж хэлэх ёстой яагад гэвэл тухайн үед компанийн удирдлагад дангаараа хөрөнгө оруулалтын ийм шийдвэр гаргах эрх байдаггүй, энийг бол хувьцаа эзэмшигчидтэй зөвшилцөж, хувьцаа эзэмшигчид зөвшөөрч байж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар гаргасан шийдвэрийн дагуу хөрөнгө оруулалтыг хийсэн байгаа. Энэ 3,2 тэрбумын хувьцаа нь манай компанийн баланс дээрээс хасагдах үед цэвэр санхүүгийн үнэ цэнийн бууралт болоод мөнгөн утгаараа тодорхой хэмжээний зардалууд гараад явсан байсан. Анх босгож байсан 2 сая долларын хөрөнгө оруулалт тодорхой төсөлд зарцуулаад үлдсэн мөнгө нь бас авлага хэлбэрээр байж байгаа. Компанийн цаашдын ирээдүйд бодитоор эрсдэл учрахгүй гэж үзэж байгаа. Үйлдвэрийн хувьд хэвийн ажиллаж байгаа. Ажилчдын тоо хэвээрээ байгаа, банкин дээр өр зээл байхгүй, хуулийн байгууллагын хязгаарлалтанд ороогүй байгаа.

2017 оны санхүүгийн тайлангийн хүлээлт бол их хэмжээний алдагдалтай гарж ирнэ, мөнгөн урсгалын хувьд компани эерэг байх нөхцөл харагдаж байгаа. Монгол дахь үйлдвэрийн үйл ажиллагаанд ямар нэгэн зардалын өсөлт байхгүй гэж ойлгож болно. Ирэх жилийн хувьд 600 сая

төгрөгийн борлуулалтын орлого үйлдвэр дээр төсөвлөсөн байгаа. Өнгөрсөн оныхтой ижил дүнгээр төсөвлөсөн байгаа.

2016 оны 8 сард компанийн удирдлага санаачлаад зардлаа таная гэсэн чиглэл гаргаад ТУЗ-р шийдвэрлэсэн ба ТУЗ-н гишүүд цалинтай байсан энэ цалинг 8 сард зогсоогоод, өнөөдрийг хүртэл ТУЗ-н зардал гэж байхгүй, үйлдвэрийн үйл ажиллагааны зардал, ажилчдын цалингийн зардал бүрдэж байна.

Одоо ТУЗ-с 3,2 тэрбум төгрөгийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх, энэ алдагдлыг цаашид яаж нөхөх талаар арга зам боловсруулахыг гүйцэтгэх удирдлагад даалгасан байгаа. Бидний хувьд цаашид хөрөнгө оруулалт хийх үү, компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх талаар төсөл хувилбарууд дээр ажиллаж байгаа. Өнөөдөр энэ талаах амжиж ярьж бодсон боловч тухайн төсөл дээрээ тогтох дээрээс нь хөрөнгө оруулагч нарт танилцуулах хугацаа амжсангүй. Хэрвээ үйл ажиллагааны өрөгөжилт, өөрчлөлт орох бол бид хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах, төсөлөө танилцуулж баталгаажуулах төлөвлөгөө байгаа.

Хурлын дарга Ө.Хүдрээ: Монгол дах үйлдвэрийг түшиглээд өргөжих, бизнес төлөвлөгөө хийж байгаа гэж ярьлаа, Хойд солонгостой холбоотой асуудал одоо шинэ ТУЗ байгуулагдсаны дараагаар хуралдаад, Пүрэвбаатар захирлын хэлсний дагуу дахиж ээлжит бус хурлаар дагуу асуудлууд яригдах болов уу. Удирдлагын хувьд цаашдын үйл ажиллагааг бид өөдрөгөөр төсөөлж байна. Жил болгоны ХЭХ дээр зарим саналыг оруулдаг. 2015,2016 онд Хойд солонгосын хөрөнгө оруулалт амжилттай явах болов уу гэсэн хүлээлт байгаад дотоод үйл ажиллагаагаа өргөжүүлэх тал дээр хүлээлтийн байдалтай байсан. Дотоод үйл ажиллагаагаа өргөжүүлээд явах боломж байгаа. Компани дотоод үйл ажиллагаагаараа ашигтай ажиллаж байна. Бид нарт тодорхой хэмжээний авлага байгаа. Дотоод үйл ажиллагаатай холбоотой мэргэжлийн хяналтын газар, байгаль орчны яам, уул уурхайн яамнаас шаардаж байгаа хөрөнгө оруулалтын асуудлууд байгаа. Энийг шийдээд явна гэсэн бодолтой байна. Дотоод үйл ажиллагаа болон Хойд Солонгостой холбоотой 2016 оны үйл явдлыг та бүхэнд танилцууллаа. Одоо асуулт байвал асуугаал хурлын дэгийн дагуу дараагийн асуудалдаа орьё.

Хувьцаа эзэмшигч: Энэ үйл ажиллагааны зардал гээд 1 тэрбум 900 орчим сая төгрөг байна. Алдагдал нь тэрбум 980 сая болож байна.

Санхүү эрхэлсэн захирал Б.Пүрэвбаатар: Энэ засвар хийгдэж байгаа баланс байгаа. Одоо бид нарын гаргасан тайлан дээр бага дүнтэй байгаа. Энд яагаад 1,9 тэрбум төгрөг орж ирсэн бэ гэхээр аудитын компани түрүүн миний хэлсэн хөрөнгө оруулалтын тодорхой хэсгээс эрсдэлийнсан үүсгэсэн болохоор энэ үйл ажиллагааны зардал дээр орж ирж байгаа.

Хувьцаа эзэмшигч: 3,2 тэрбумаас гадна уу?

Санхүү эрхэлсэн захирал Б.Пүрэвбаатар: 3,2 тэрбум дотроо, 3,2 тэрбумыг энэ засвар дээр оруулаагүй. Яагаад гэвэл хугацаагаараа процесс нь болоогүй байсан. Аудитууд бол энэ үед

эрсдэл үүсэж магадгүй гээд хэсэгчлээд эрсдлийн сангийн дүн орж ирээд 1,9 тэрбум болж байгаа. Энэ бол бодитой компанийн үйл ажиллагааны зардал биш. Дээд тал нь 3,2 тэрбум гэж үнэлээд энэ жил 30,40% дээр нь эрсдэлийн сан үүсгээд 2016 оны тайлан дээр засвар оруулах санал оруулсан байгаа. Бид эрсдэлийн санг зөвшөөрч байгаа учир нь 2017 оны тайлан дээр 3,2 тэрбумаар зөвшөөрснөөс 2016 ондоо 1,9 тэрбумын алдагдлаа зөвшөөрвөл зөрүү 1,3 тэрбумын алдагдалыг 2017 оны тайлан дээр оруулж ирнэ.

Хувьцаа эзэмшигч: 200 сая төгрөгийн ашигтай гэсэн байна.

Санхүү эрхэлсэн захирал Б.Пүрэвбаатар: Үйл ажиллагааны ашиг нь цэвэр монгол дахь үйлдвэрийн тоо явж байгаа.

Хувьцаа эзэмшигч Компанид нөлөөлөхгүй гэж ярьж байна.

Хурлын дарга Ө.Хүдрээ: 1 сарын мэдэгдлээс хойш бид нар эхний удаагийн ажил нь хуулийн талын асуудлуудыг шийдэж байна, одоо хурал болсоны дараа шинэ ТУЗ байгуулаад санхүүгийн асуудлыг тусад нь авч хэлэлцээд санхүү дээр гарсан шийдвэрээ ээлжит бус хурал зарлаж дахиж хэлэлцэх ийм төлөвлөгөөтэй байгаа.

Хувьцаа эзэмшигч Гарсанаа мэдэгдэхээр хөрөнгө оруулалтын компани ямар нэгэн мэдэгдэл өгсөн үү?

Санхүү эрхэлсэн захирал Б.Пүрэвбаатар: Бид нар хөрөнгө оруулагч компаниа авч үлдэхийн тулд Хойд Солонгосын хөрөнгө оруулалтаас гарж байгаа нь компанийн ирээдүйг бодож байгаа юм.

Хувьцаа эзэмшигч Тийм тохиолдолд эрсдэл 100% үүсэх үү?

Санхүү эрхэлсэн захирал Б.Пүрэвбаатар: Манай дээр бол 100% үүсэж байгаа. Компаний ирээдүйг бодоод өөрсдөө татгалзаж, хөрөнгө оруулалтаа орхиж байгаа юм.

Хувьцаа эзэмшигч: Жагсаалтаас гарчлаа гэхэд яах уу?

Хувьцаа эзэмшигч: Жагсаалтаас гарлаа гээд буцаагаал гэрээгээ сэргээх эсвэл нөгөө талаас хүсэлт ирэх, хоёр талаасаа ярилцах л асуудал.

Хувьцаа эзэмшигч: Монголд бизнес хийхэд Ардчилсан Солонгосоос дор л байна. Шинэ төсөл гэж бодож байгаа юм байна уу?

Хурлын дарга Ө.Хүдрээ: НӨАТ баримт гарж ирсэнээс хойш манай санхүү баримттай болоод байна. Хоёрдагч түүхий эд авдаг учраас НӨАТ-тэй бараагаа зардаг хүн байхгүй, тэгэхээр тэр хүний НӨАТ-г компанийн борлуулалтын НӨАТ-тэй нийлүүлж улсад төлж байсан. Нийт дүнгээрээ 180 сая татвар төлж байна. Хог хаягдалын тухай хууль хэлэлцэгдээд явж байна.

Цуглуулж аваад, эргэлтэнд оруулаад, өртөг шингээгээд, бүтээгдэхүүн болгож байгаа мөнгөн дүн яригдаад байгаа. Цаана нь бас өөр хохирол яригдаж байгаа, бид нар 600,800 тонныг цуглуулж авж байна. Хэрвээ 600 тонн байгаль дээр асгарвал ямар хэмжээний хохирол байгальд учрах вэ гэсэн үнэлгээ хийдэг, тэрний дагуу цуглуулж авсан компанид нь улсаас татаас, урамшуулал өгдөг хуулийн заалт дэмжигдээд гараад ирвэл бид нар нэмэлт орлого орох, байгаль орчинд ээлтэй үндсэн төслийн зорилго маань хуулийн хүрээнд баталгаажих процесс явагдаж байна. Болох болов уу гэсэн хүлээлт байна. Одоо Энэтхэгийн ЗГ-н зээлээр 2 тонны нефть боловсруулах үйлдвэр Сайншандад барина гэсэн төсөл явж байна. Удирдлагын хувьд мэргэжлийн удирдлага ажиллаж байна. Би энэ салбарт 20 гаруй жил ажиллаж байна. Зах зээл дээр шинэ бизнес төсөл нь импортын түүхий эдэнд түлгүүрласан, бага оврын хүчин чадалтай, нефть боловсруулах үйлдвэр барья гэсэн төслийн тооцоо хийж байна. Ойролцоогоор жилийн 15000 тонны хүчин чадалтай хийн конденсат гэдэг түүхий эдийг ашиглаад 50% бензин, 30% дизель, 20% мазут, үйлдсэн нь машинд хийдэг пропан газ гээд 99 % гарцтай, орчин үеийн циолит ашигласан катализатортой, Зи формогийн процесстой, нефть боловсруулах мини үйлдвэр барихаар Томскийн мэргэжилтэнгүүдтэй ажиллаж байна. Түүхий газрын тосны 1 баррелийн үнэ 50 доллар байлаа гэхэд пропан шилжүүлэхээр ойролцоогоор 370 орчим доллар гардаг. Бид нарын оруулж ирэх гэж байгаа түүхий эд нефтнээс 100 доллараар хямд байдаг. Бид нарын түүхий эд оруулж ирээд онцгой татвар, гаалийн татвар төлнө, НӨАТ төлөхгүй. Дотооддоо борлуулаад нэг тоонд оногдох дотоод үйл ажиллагааны зардалыг 70-80 доллар гэж тооцоход, бид нар жилдээ 15000 тонн бүтээгдэхүүн зах зээлд гаргана гэж тооцвол 15-20%-н маржинтай ажиллах боломж байгаа. Гарж ирж байгаа бүтээгдэхүүн нийт монголын орж ирэх импортын 1% орчим байхаар тооцоо хийж байгаа. Энэ шинэ технологио эзэмшээд, дадлагажаад, дахиад бараг өөрийнхөө үйл ажиллагаагаар хүчин чадлаа нэмэх зорилготой бизнес төлөвлөгөө хийгээд байна.

Хувьцаа эзэмшигч: Хэдэн жил болох уу?

Хурлын дарга Ө.Хүдрээ: Үйлдвэр ашиглалтанд орох хугацаа 9 сар, түүхий эд жилийн турш 15000 тонныг татна гэвэл хоногтоо нэг 150 орчим үйлдвэрлэнэ. Энэ үйлдвэр 2 жил ажиллахад хөрөнгө оруулалтаа нөхнө. Дотоод зах зээл байна гэж үзэж байна.

Хувьцаа эзэмшигч: Зөвшөөрөл яаж авах уу?

Хурлын дарга Ө.Хүдрээ: Бүтээгдэхүүн хуваах гэрээний зарчмаар явна, Монголд оногдох хэмжээ нь 40% гэж ярьдаг ч гэсэн 26 % байдаг. 1 сая тонныг экспортоор гаргаж байна. 260000 тонн монголд оногдож байна. Үлдсэнийг нь үйлдвэр баригдвал үлдсэн тосыг нь Дайчин Тамсагаас худалдаж авах санаа явж байна. ЗГ 100% дотоодын түүхий эдэнд тулгуурласан нефть боловсруулах үйлдвэр барья гэхээр зөвшөөрдөггүй, импортын хийн конденсат ашиглаад үйлдэр барья гэхээр одоогийн байдлаар 2 компани боловсруулах үйлдвэрийн зөвшөөрлөө авсан байгаа. Бид нарын зүгээс бичиг баримтаа боловсруулаад, ТЭЗҮ хийгээд уул уурхайн яаманд хийн

конденсатаас нефть боловсруулах үйлдвэр барина гэхэд лиценз гарах боломжтой. Түүхий эдээ импортлох лиценз, бөөний болон жижиглэнгээр борлуулах зөвшөөрөл авна.

Хувьцаа эзэмшигч: Түүхий эдээ хаанаас авах уу?

Хурлын дарга Ө.Хүдрээ: Ангарскийг тойроод 3 газрын конденсатын орд байгаа, 3 орд өөр өөр шинжтэй. Тэндээс авах боломжтой.

Хувьцаа эзэмшигч: Шарын голын өр авлага гэж юу ярьж байна?

Санхүү эрхэлсэн захирал Б.Пүрэвбаатар: Хойд Солонгост хөрөнгө оруулахын тулд 2 сая доллар бэлнээр боссон. Бага зардалтай төсөл рүү орсон, үлдсэн 600000 долларыг тухайн үед хадгаламжинд байршуулсан. Шарын гол бол том нүүрсний компани, хадгаламжийн хүүнээс өндөр хүүгээр зээлэх санал тавьсан, тухайн үед ашиглагдаагүй мөнгөө үр ашигтайгаар зарцуулах үүднээс долларын зээл өгсөн. Тайлан дээр валютын ханшны хэрэгжээгүй ашиг өндөр гардаг. Ойролцоогоор 500 орчим сая төгрөг. Шинээр яригдаж байгаа төслийг санхүүжүүлэхээр яригдаж байгаа. Бид нар бүх босгосон мөнгөө үрээгүй, компани нэг талаасаа аюулгүй байгаа нь энэ авлагатай ч холбоотой.

Хурлын дарга Ө.Хүдрээ: Санхүүгийн асуудлын талаар энэ бүхэн хамтдаа шийдэгдэх байх.

Хувьцаа эзэмшигч: Үйлдвэрийн тооцоолол дууссан уу?

Хурлын дарга Ө.Хүдрээ: Эцсийн байдлаар гараагүй, зарим зүйлийг монголчлоод явж байна. Томскийн нэлээн гайгүй компанитай ярьж байгаа, түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр бүх юмаа хийлгэе гэсэн санал авсан явж байгаа. Дэд бүтцээ өөрсдөө хийвэл хэд вэ гэсэн санал явж байна. Түүхий эдийн шинж чанараас шалтгаалаад тоног төөхөөрөмжин дээр нэмэлт юу юу байхыг ярилцаад байна.

Хувьцаа эзэмшигч: Үйлдвэрийг барихад хувьцаа гаргах уу?

Хурлын дарга Ө.Хүдрээ: Үгүй гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигч: Гэрээ хийсэн үү?

Санхүү эрхэлсэн захирал Б.Пүрэвбаатар:

Санхүү эрхэлсэн захирал Б.Пүрэвбаатар: Гэрээ хийгээгүй байгаа. Нэмэлт хөрөнгө босгоход хүндрэлтэй. Дараагийн хэрэгжүүлэх төслийг жижиг хэмжээнд багтаагаад байгаа нь нөөц бололцоондоо тулгуурлаж байна. Шинэ хөрөнгө оруулалтанд найдаад том юм яриад явбал хурдан хэрэгжих нь хэцүү. Одоо байгаа мөнгөн дүнгээ ашиглаад, бэлэн мөнгө хурдан эргэлддэг тийм төсөл рүү орох нь компанид хамгийн ашигтай.

Хувьцаа эзэмшигч: Алдагдлаар бүртгэхээр хувьцаага хасах уу?

Санхүү эрхэлсэн захирал Б.Пүрэвбаатар:

Санхүү эрхэлсэн захирал Б.Пүрэвбаатар: Хөрвөсөн хувьцааг хасна гэж хэцүү, улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалаад зогссон тул зөвхөн хувьцаа эзэмшигчид 100% хариуцлага хүлээлгэх нь хэцүү, тэд нар ч тэр төсөлд тодорхой хэмжээгээр хугацаа зарцуулаад явж байгаа. Тайлан дээр хуримтлагдсан алдагдал баланс дээр үүснэ.

Хувьцаа эзэмшигч: Хасах 2 турбумын алдагдал үүснэ, хувьцааны үнэ буурах байх.

Хурлын дарга Ө.Хүдрээ: Дотоодын үйл ажиллагааг дагуулаад хувьцааны үнэ унагаахгүйг хичээж байна. Өвөл бас бүтээгдэхүүнээ борлуулья гэсэн төлөвлөгөө байна. Станцуудын жилийн худалдан авалт 3-4 тэрбум төгрөг орчим байдаг. Манай гаргаж байгаа мазут оросын М-100 мазуттай төстэй, адилтгаж хийж байгаа зүйл. Тэр нь оросын стандартаар сертификаттай орж ирдэг бүтээгдэхүүн. Манайх 4 улиралд ажиллаад станцуудын хэрэглээг хангаж дийлэхгүй. Туршихаар болдог тэгсэн хирнээ авдаггүй. Тендерт орьё гэхээр оросын стандартыг тавьдаг. Хэлэлцэх асуудал дууссан тул яриагаа үргэлжлүүлэнгээ хурлын дэгийн дагуу саналын хуудсаа бөглөнө үү.

Хурлын төгсгөлд тооллогын комиссын дарга Б. Мянганбаяр санал хураалтын дүнг танилцуулав:

Тооллогод нийт хувьцаа эзэмшигчдийн 87,77 % буюу 45,743,705 ширхэг хувьцаа эзэмшиж буй 15 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас ирснээс 12 саналын хуудас, 83,15 % буюу 43,325,126 ширхэг хүчинтэй саналын хуудас байлаа.

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

3. 2017 оны бизнес төлөвлөгөө хэрэгжүүлэх тухай хувьцаа 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

4. Компанийн шинэ ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдээс **Б.Лхагвадорж 12.09%, Ө.Хүдрээ 12.09%, Б.Пүрэвбаатар 10.14%, Д.Даянбилгүүн 12.09%, Ж.Эрдэмбилэг 5.5%, Б.Мянганбаяр 5.26%** - ийн санал авч хараат гишүүдэд сонгогдлоо.

Хараат бус гишүүдэд **М.Батсүрэн 10.14%, Х.Батхишиг 13.06%, Б.Болормаа 10.14%**- ийн саналтайгаар сонгогдлоо.

5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2017 оны зардлын төсвийг батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

Хурал 15:30 өндөрлөв.

Хурлын протокол хянасан хурлын дарга: /Ө.ХҮДРЭЭ/



Хурлын протокол хөтөлсөн: /Ж.ЭНХЦЭЦЭГ/